



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 06 өдөр

Дугаар 1/653

Есөнбулаг

Гамшгийн сангаас хөрөнгө
зарцуулах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32.1.1 дахь заалт, аймгийн Онцгой комиссын 2023 оны 23 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааны зардал 1,500,000 (нэг сая таван зуун мянга) төгрөгийг аймгийн Гамшгийн сангаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

2. Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх ажлын үр дүнг танилцуулахыг Ус, цаг уур орчны шинжилгээний төв (Н.Алтантуяа)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

